

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Улиастай

Завхан аймгийн бодлогын баримт бичгүүд /Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө/-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын аймгийн бодлогын баримт бичгүүдийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн зөвлөмжийн дагуу бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд сайжруулалт хийж, Хяналт-шинжилгээ, үнэлгээг 3 удаа гүйцэтгэлээ.

Гурав. Аймгийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, анхаарах асуудал

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 8 бодлого, 27 зорилт 120 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хэрэгжилтийг харуулбал:

Хяналтад авсан бодлого		Бүгд	Бодлого, арга хэмжээгээр							
			I.Үндэсний нэгдмэл үнэт зүйл	II.Хүний хөгжил	III.Амьдралын чанар ба дундаж давхарга	IV.Эдийн засаг	V.Засаглал	VI.Ногоон хөгжил	VII.Амар тайван амьдрал	VIII.Бүс, орон нутгийн хөгжил
Арга хэмжээний үнэлгээ										
Хяналтанд авсан нийт бүлгийн тоо		8	1	1	1	1	1	1	1	1
Хяналтанд авсан нийт зорилтын тоо		26	1	4	5	3	3	3	4	3
Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо		120	7	21	31	16	8	12	11	14
Үр дүнтэй 100.0%			-	-	-	-	-	-	-	-
Тодорхой үр дүнд хүрсэн	90.00%	3	-	1	-	1	-	1	-	-
	70.00%	16	1	1	-	2	-	4	4	4
Эрчимжүүлэх шаардлагатай	50.00%	78	6	19	17	11	5	6	6	8
	30.00%	22	-	-	13	2	3	1	1	2
Үр дүнгүй 0%		1	-	-	1	-	-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/		51.04	52.8	52.5	39.85	52.5	42.22	62.5	57.5	48.41

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа зорилт, арга хэмжээ, хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнахгүй, дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар санал санаачилга гаргаж ажиллахгүй байх зэрэг дутагдал хэлтэс, агентлаг, бодлогын мэргэжилтнүүдэд нийтлэг байна.

Тухайлбал аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 120 арга хэмжээний 41 арга хэмжээ буюу 34,1 хувийг аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна. 79 арга хэмжээг Засгийн газрын тогтоол, шийдвэр, төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн байна.

Мөн зарим арга хэмжээний хүрээнд тодорхой ажил зохион байгуулаагүй, төлөвлөөгүй, 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлээр хэрэгжилтийг бичих зэрэг алдаа дутагдал байна. Энэ нь тухайн мэргэжилтний санаачлагатай байдал дутагдсан гэж үзэж байна.

Таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгүй хэрэгжиж байгаа 1 арга хэмжээг дахин сайтар судлаж үнэхээр хэрэгжих боломжгүй бол хасуулах, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах талаар арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6 бодлого, 26 зорилт, 286 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хэрэгжилтийг харуулбал:

Хяналтад авсан бодлого		Бүгд	Бодлого, арга хэмжээгээр					
			I."Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг давах туулах арга хэмжээ	II.Хүний хөгжлийн бодлого	III.Эдийн засгийн бодлого	IV.Засаглалын бодлого	V.Ногоон хөгжил	VI.Бүс, нутгийн хөгжлийн бодлого
Арга хэмжээний үнэлгээ								
Хяналтанд авсан нийт бүлгийн тоо		6	1	1	1	1	1	1
Хяналтанд авсан нийт зорилтын тоо		26	2	6	7	6	4	1
Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо		287	8	103	95	33	30	18
	Үр дүнтэй 100.0%	97	8	34	20	16	16	3
	90.00%	111	-	52	37	8	7	7
	70.00%	48	-	11	24	5	3	5
	50.00%	10	-	3	5	1	-	1
	30.00%	14	-	3	9	-	1	1
	Үр дүнгүй 0%	6	-	-	1	2	2	1
Биелэлтийн дүн /хувь/		86.96	100	89.33	77.48	89.67	87.06	78.24

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 286 арга хэмжээнээс 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 84 арга хэмжээ буюу 29,3 хувийг тусган хэрэгжүүлсэн байна. 202 арга хэмжээг 2021 онд хэрэгжүүлсэн, мөн төрийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн ажил арга хэмжээ байна.

1 хэрэгжүүлсэн ажлыг 2-3 арга хэмжээний хэрэгжилтэд бичиж биелэлтийг хааж байгаа нь мэргэжилтнүүдийн санаачлага дутсан, ажил хийгээгүй байгаа зүйл ажиглагдаж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр жил бүрээр шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлон батлуулсан хэдий ч 2022 онд хүрэх зорилтот түвшинд хүрээгүй, огт ажил хийгдээгүй арга хэмжээнүүд байна.

Мөн зарцуулах төсвийг тавьсан хэдий ч тухайн төсөв аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Хүний хөгжлийн бодлогын хүрээнд төлөвлөсөн дараах арга хэмжээний төлөвлөлт, шалгуур үзүүлэлт, төсөв, зорилтот түвшинг дахин ярилцаж тодорхойлох нь зүйтэй байна. Үүнд:

2.1.1.10-т заасан бодлогын зөвлөл байгуулах эрх зүйн үндэслэл болсон бодлогын баримт бичиг нь хүчингүй болсон.

2.2.1.2, 2.2.3.1, 2.2.8.1-т заасан арга хэмжээнүүдийн хүрэх түвшинг судлах.

2.3.6.1, 2.4.1.1-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарах.

2.5.6.1, 2.5.8.1, 2.5.12, 3.1.8.1, 3.1.10.1, 3.3.3.1-т заасан арга хэмжээнүүдийг 2023 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн байна. Үүнийг 2023 онд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

2.6.4.1, 2.6.4.2, 3.1.9.3, 3.1.9.2, 3.1.9.3, 3.1.14.1-3.1.14.4-т заасан арга хэмжээнүүдийн үндсэн хэрэгжүүлэгч байгууллагыг чиг үүргийнх нь дагуу зөв тодорхойлох.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд судалгаа хийж, орон нутгийн зүгээс хийх боломжийг судлаж ажиллах.

**Аймгийн 2022 оны хөгжлийн
жилийн төлөвлөгөөний
хэрэгжилт**

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө 6 бодлого, 24 зорилт, 236 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжилтийг харуулбал:

Хяналтад авсан бодлого		Бүгд	Бодлого, арга хэмжээгээр					
			I."Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг давах туулах арга хэмжээ	II.Хүний хөгжлийн бодлого	III.Эдийн засгийн бодлого	IV.Засаглалын бодлого	V.Ногоон хөгжил	VI.Бүс, нутгийн хөгжлийн бодлого
Арга хэмжээний үнэлгээ								
Хяналтанд авсан нийт бүлгийн тоо		6	1	1	1	1	1	1
Хяналтанд авсан нийт зорилтын тоо		24	1	6	6	6	3	2
Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо		236	2	52	44	41	22	75
	Үр дүнтэй 100.0%	164	2	43	34	28	18	39
	90.00%	25	-	6	7	5	1	6
	70.00%	30	-	1	-	5	1	23
	50.00%	5	-	-	1	1	-	3
	30.00%	10	-	1	2	2	2	3
Үр дүнгүй 0%		1	-	1	-	-	-	-
Биелэлтийн дүн /хувь/		90.07	100	95.78	94.19	91.5	74.74	84.21

Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ /ЗӨВЛӨМЖ/

-Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах.

-Үр дүнгүй хэрэгжиж байгаа арга хэмжээний төлөвлөлт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг арга хэмжээ бүрээр дахин нягтлаж харах.

-Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг дахин нягтлаж цаашид бүрэн хэрэгжих боломжтой эсэх, боломжгүй бол өөрчлөх, хасах санал боловсруулах.

-Бодлогын баримт бичгийн уялдаа, салбар хоорондын уялдааг хангаж, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг анхаарч, богино хугацааны бодлогын баримт бичигт (жил бүрийн хөгжлийн төлөвлөгөө) тусган төлөвлөж байх.

-Бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах талаар аймгийн ИТХ-д санал уламжилсан тул бодлогын мэргэжилтнүүд бодлогын баримт бичигт тусгагдсан салбарынхаа зорилт арга хэмжээний төлөвлөлт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, төсөв зэргийг дахин нягтлаж өөрчлөлт оруулах.

-Бодлогын баримт бичиг нэмэлт өөрчлөлт оруулахдаа тухайн арга хэмжээг ямар шалтгаанаар нэмэлт өөрчлөлт оруулах, цаашид хэрэгжих боломжтой эсэхэд үндэслэл, нотолгоотой, судалгааг гаргаж саналаа Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэх.

-Хяналт-шинжилгээ, үнэлгээтэй ажилтан бүр танилцаж, гаргасан алдаа дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах.

-ХШҮ-ний тайлан зөвлөмжөөр өгсөн үүрэг даалгавар, гаргасан алдаа дутагдлыг арилгах талаар хийсэн ажлын тайланг 2023 оны II улирлын хэрэгжилтийн тайлангийн хамт ирүүлэхийг мэдэгдье.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг цахим шуудангаар хүргүүлэв.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС